



ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Дорнод аймгийн Булган сумын Цэцэрлэгийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: ДОА-2020/138/СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn

Чойбалсан хот

2020 он

Тэргүүлэх аудитор: Б.Болортуул

Утас: 7058-4203 Цахим хаяг: bolortuulb@audit.gov.mn

Аудитын менежер: В.Цэнгэлмаа

Утас: 7058-4204 Цахим хаяг: tsengelmaav@audit.gov.mn

Аудитор: Э.Нандинчимэг

Утас: 7000-3775 Цахим хаяг: khaanconsultingaudit@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
ЗТХС	Зам Тээвэр Хөгжлийн Сайд
ДОА	Дорнод аймаг дахь Төрийн аудитын газар
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
ТШЗ	Төсвийн шууд захирагч



АГУУЛГА

Аудитын гэрчилгээ	1
Аудитын тайлан.....	3
2.1. Оршил.....	3
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	3
2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	4
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин.....	4
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ.....	4
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	4
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар.....	5
2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	5
2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	6
2.10. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	6
2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал ..	7
2.12. Шилэн дансны мэдээлэл	7
2.13. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга.....	7
2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	7
Менежментийн захидал	8
Аудит хийгдсэн санхүүгийн тайлан	9
4.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан	9
4.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	10
4.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	11
4.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	12
4.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	12




**ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**
21000, Дорнод аймаг, Хэрлэн сум 7-р баг
ЗДТГ-ын II байр, Утас/Факс: 7058-4203

2019.02.27 № 208

танай _____ -ны № _____ -г

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дорнод аймгийн Булган сумын Цэцэрлэгийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Дорнод аймгийн Булган сумын Цэцэрлэгийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн Сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын Олон Улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Дорнод аймгийн Булган сумын Цэцэрлэгийн 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

110520114



Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1 дэх заалтын дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн Сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.БОЛОРТУУЛ



2.1. Оршил

Булган сумын цэцэрлэгийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг эрхлэгч Б.Шархүүхэн танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Булган сумын Цэцэрлэгийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Булган сумын Цэцэрлэгийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 01 дүгээр сарын 26-наас 2020 оны 02 дугаар сарын 21-ний хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 02 дугаар сарын 27-ны өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, аудитор Э.Нандинчимэг хариуцаж хэрэгжүүлэв.

Булган сумын Цэцэрлэгийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Дорнод аймаг дахь төрийн аудитын газарт 2020 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн 02 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.



2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Булган сумын Цэцэрлэгийн үйл ажиллагааны эрхэм зорилго нь “Хүүхдийг тоглоомоор дамжуулан, мэдлэг бүтээх хөгжих, суралцах, бүхий л идэвхитэй үйлдэлийг дэмжсэн баяр баясалтай орчин бий болгох”-д оршино.

Цэцэрлэгийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ: Үүнд:

- СӨБ-н хамтран сургалтыг нэмэгдүүлнэ
- Багш ажилтан бүр ёс зүйн зөрчлөөс сэргийлнэ
- Хүн болох багаас хөтөлбөр хэрэгжүүлнэ
- Хөдөөгийн малчдын хүүхдэд гэр цэцэрлэгээр дамжуулан СӨБ олгоно.
- АБ-н аюулгүй байдал бүрэн хангаж ажиллана.

Тухайн байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг гол хууль тогтоомж, түүнд нийцүүлэн гаргасан журам зааварт өөрчлөлт ороогүй байна.

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Булган сумын Цэцэрлэгийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцтэй байна.

Булган сумын Цэцэрлэг нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд “Ахplorer” программ хангамж ашигладаг байна.

Булган сумын Цэцэрлэгийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналтын үр нөлөө дунд гэж үзлээ.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитын явцад бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.



Аудитыг төлөвлөлтийн үе шатанд 30 эрсдэлтэй асуудалд горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2019 оны жилийн эцсийн үр дүнгийн тайлангийн зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг дунд гэж үнэлэн материаллаг байдлын хэмжээг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 202,915.4 мянган төгрөгөөс тооцон 4,058.3 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, гүйцэтгэлийн үе үатанд хэвээр баталгаажууллаа.

2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Булган сумын Цэцэрлэгийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 4,814.63 мянган төгрөгөөр буюу 1,01 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/ мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Бараа материал	27,111.97	36,766.58	9,654.61
Үндсэн хөрөнгө	493,637.43	494,757.43	1,120.00
Хуримтлагдсан элэгдэл	(45,075.96)	(60,665.20)	(15,589.24)
Нийт хөрөнгө	475,673.43	470,858.81	(4,814.63)
Өр төлбөр			-
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	475,673.43	470,858.81	(4,814.63)
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	475,673.43	470,858.81	(4,814.63)

Бараа материалын дансны үлдэгдэл 9,654.6 мянган төгрөгөөр өссөн нь заах аргын хэрэгслүүд болон хүүхэд хөгжлийн материалууд авсантай холбоотой байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл өссөн нь 1,120.0 мян төгрөгөөр Принтер болон нарны зайн төхөөрөмж авсантай холбоотой байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл өөрчлөлт ороогүй байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 470,858.8 мянган төгрөг болж 4,814.6 мянган төгрөгөөр буурсан нь үндсэн хөрөнгийн хуримтлагдсан элэгдлээс шалтгаалжээ.



2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Тайлант онд Төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрт зориулан үндсэн үйл ажиллагаанд 187,129.0 мянган төгрөгийн төсөв батлагдсан нь урсгал зардалд зарцуулахаар батлагджээ.

Нийт зардлын 169,029.0 мянган төгрөгийг улсын төсвөөс, 18,100.0 мянган төгрөгийг орон нугийн төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 187,113.3 мянган төгрөг буюу 99.99 хувьтай байна.

Нэмэлт төсөв: Нэмэлт санхүүжилтийн дансанд 1,500.0 мянган төгрөгийн орлого орж, зориулалтын дагуу зарцуулагдсан байна.

2.10. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 30 эрсдэл, гүйцэтгэх үе шатанд эрсдэл тогтоож 30 эрсдэл тодорхойлж нийт 30 горим сорил хэрэгжүүллээ.

Аудитаар нийт 33,302.5 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 33,020.5 мянган төгрөгийн зөрчилд 3 албан шаардлага хүргүүлж, 282.0 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 1 зөвлөмж өглөө. Дээрх залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг дараах байдлаар ангилав.

Аудитаар дараах 33,020.5 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа, зөрчилд албан шаардлага хүргүүллээ. Үүнд:

1. Тайлант хугацаанд гарсан зардлаас 24,527.9 мянган төгрөгийн зардлыг и-баримт цахим системд бүртгүүлээгүй нь СС-ын 2017 оны 347 дугаар тушаалаар батлагдсан “Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх заавар”-ын 6.5 дахь Монгол Улсын стандарт MNS 6529:2015 “татварын нэгдсэн системд ашиглах төлбөрийн баримтын ерөнхий шаардлага”-д заасан тусгай нууцлалын QR кодоор баталгаажсан анхан шатны цаасан баримтуудыг бүрдүүлж ажил гүйлгээг хүлээн зөвшөөрөх гэсэн тушаалыг бүрэн хангаж ажиллалаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэв.

1. Бараа материалыг эхний болон эцсийн үлдэгдэлд 7,276.2 мянган төгрөгийн материалыг нэр төрөл, үнийн дүнг тусгаагүй багцаар нь бүртгэсэн байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.7 дахь хэсгийн “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно”, Төсвийн тухай хуулийн 41.2.3. дахь “төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах” гэсэн заалтад нийцэхгүй, санхүүгийн тайлангийн толилуулга ба тодруулга, хэмжилт, үнэн зөв байдал гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.



Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэв.

2. Хүнсний материал нийлүүлэх гэрээний үнэ болон бодит худалдан авалтын үнийн зөрүү 1,216.4 мянган төгрөг байгаа нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 41.1.2-т заасан гэрээний үнийг өөрчлөх тухай заалтад нийцэхгүй санхүүгийн тайлангийн үнэн зөв байдал гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэв.

Аудитаар илэрсэн 282.0 мянган төгрөгийн алдаа, зөрчилд 1 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгалаа.

2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

1. Бараа материалын орлогыг бүртгэлд тусгахдаа нэр төрөл бүрээр ангилж бүртгэх.
2. Худалдан авалтын гэрээний нэгжийн үнэ, түүний өөрчлөлтийг нягтлан шалгах.

2.12. Шилэн дансны мэдээлэл

Булган сумын Цэцэрлэг нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан 145 мэдээллийг хугацаанд нь, 2 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

2.13. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлсэн байна.

2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Булган сумын Цэцэрлэгийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

“Зөрчилгүй” дүгнэлт

Булган сумын Цэцэрлэгийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3, УСНББОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.



Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1. Тайлант хугацаанд хэрэгжүүлэх ерөнхий чиглэл

1.1 Илрүүлэлт: 2005 онд ашиглалтанд орсон CTS санхүүгийн програм 82,0 мян төгрөг, Архивын програм 200,0 мян төгрөгийн өртөгтэй бүртгэлд тусгагдаж байна. Одоо ашигладаггүй, ашиглалтын хугацаа дууссан.

1.2 Эрсдэл: Ерөнхий чиглэлийн дагуу нэгдсэн журмаар тогтоосон эрсдэл

1.3 Өгсөн зөвлөмж: Ашиглалтын хугацаа дууссан хөрөнгийг данснаас хасах саналтай байна.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2020 оны 05 дугаар сарын 15-ны дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.



Аудит хийгдсэн санхүүгийн тайлан

4.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	27,111,966.80	36,766,578.70
35	БАРАА МАТЕРИАЛ	27,111,966.80	36,766,578.70
354	Хангамжийн материал	27,031,966.80	36,686,578.70
35410	Бичиг хэргийн материал	1,666,688.00	1,666,688.00
35420	Аж ахуйн материал	23,338,148.00	23,338,148.00
35470	Бусад хангамжийн материал	2,027,130.80	11,681,742.70
35600	Мал амьтад	80,000.00	80,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	448,561,466.42	434,092,229.24
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	448,561,466.42	434,092,229.24
392	Биег хөрөнгө	442,561,466.42	428,092,229.24
39201	Барилга, байгууламж, орон сууц	392,227,282.11	392,227,282.11
39202	Хуримтлагдсан элэгдэл	-	(7,263,468.24)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	24,809,230.00	25,929,230.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(19,701,229.92)	(20,621,980.02)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	53,373,507.82	53,373,507.82
39208	Хуримтлагдсан элэгдэл	(22,175,803.75)	(27,234,696.83)
39214	Бусад үндсэн хөрөнгө	17,227,406.00	17,227,406.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(3,198,925.84)	(5,545,051.60)
393	Биег бус хөрөнгө	6,000,000.00	6,000,000.00
39301	Програм хангамж	282,000.00	282,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(282,000.00)	(282,000.00)
39303	Бусад биег бус хөрөнгө	6,000,000.00	6,000,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III-I+II	475,673,433.22	470,858,807.94
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	475,673,433.22	470,858,807.94
51	Засгийн газрын хувь оролцоо	475,673,433.22	470,858,807.94
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	623,778,413.00	623,778,413.00
51101	Өмч - төрийн	623,778,413.00	623,778,413.00
512	Хуримтлагдсан үр дүн	(206,486,933.50)	(211,301,558.78)
51210	Өмнөх үеийн үр дүн	(206,486,933.50)	(206,486,933.50)
51220	Тайлант үеийн үр дүн	-	(4,814,625.28)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	58,381,953.72	58,381,953.72
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI-IV+V	475,673,433.22	470,858,807.94



Булган сумын Соёлын төвийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

4.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	188,033,600.00	198,100,800.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	16,386,000.00	9,471,800.00
120	Нийтлэг татварын бус орлого	16,386,000.00	9,471,800.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	16,386,000.00	9,471,800.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	16,386,000.00	9,471,800.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	171,647,600.00	188,629,000.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	170,473,300.00	169,029,000.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	170,473,300.00	169,029,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	1,174,300.00	1,500,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,174,300.00	1,500,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	-	18,100,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	-	18,100,000.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	189,383,807.28	202,915,425.28
21	УРСГАЛ ЗАРДАЛ	189,383,807.28	202,915,425.28
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	185,104,966.28	202,899,787.28
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	108,549,100.00	121,806,500.00
210101	Үндсэн цалин	83,723,823.00	105,275,900.00
210102	Нэмэгдэл	6,178,200.00	6,392,700.00
210104	Урамшуулал	8,185,100.00	10,137,900.00
210105	Гэрээт ажлын хөлс	10,461,977.00	-
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	12,573,620.00	15,950,800.00
210201	Тэтгэврийн даатгал	8,273,420.00	11,006,700.00
210202	Тэтгэмжийн даатгал	1,075,000.00	1,235,700.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	860,100.00	988,900.00
210204	Ажилгүйдлийн даатгал	214,900.00	247,200.00
210205	Эрүүд мэндийн даатгал	2,150,200.00	2,472,300.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	10,726,410.00	13,237,969.00
210301	Гэрэл, пахилгаан	3,370,647.00	3,221,969.00
210302	Түлш, халаалт	7,355,763.00	9,116,000.00
210303	Цэвэр, бохир ус	-	900,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	5,029,960.00	2,260,740.00
210401	Бичиг хэрэг	999,260.00	778,660.00
210402	Тээвэр, шатахуун	1,600,000.00	113,280.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	445,500.00	494,200.00
210404	Ном, хэвлэл	235,200.00	-
210406	Бага үнэтэй, дүргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,750,000.00	874,600.00
2105	Нормативт зардал	27,437,489.00	27,822,253.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	100,000.00	150,000.00
210502	Хоол, дүнс	27,337,489.00	27,672,253.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	-	4,848,000.00
210604	Урсгал засвар	-	4,848,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	180,000.00	380,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	200,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	180,000.00	180,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	20,608,387.28	16,593,525.28
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,450,000.00	1,004,288.10
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хоргодол	18,158,387.28	15,589,237.18
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	4,278,841.00	15,638.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	4,267,200.00	-
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	4,267,200.00	-
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	11,641.00	1,607.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	11,641.00	1,607.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	-	14,031.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	14,031.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	(1,350,207.28)	(4,814,625.28)
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	135,239,263.73	-
225007	Хөрөнгийн дахин үнэлгээний зардал	135,239,263.73	-
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	(135,239,263.73)	-
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	(136,589,471.01)	(4,814,625.28)



4.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан /төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	171,647,600.00	188,629,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	171,647,600.00	188,629,000.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	170,473,300.00	169,029,000.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	170,473,300.00	169,029,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	1,174,300.00	1,500,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,174,300.00	1,500,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	-	18,100,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	-	18,100,000.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	171,647,600.00	188,629,000.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	171,647,600.00	188,629,000.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	167,368,759.00	188,613,362.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	108,549,100.00	121,806,500.00
210101	Үндсэн цалин	83,723,823.00	105,275,900.00
210102	Нэмэгдэл	6,178,200.00	6,392,700.00
210104	Урамшуулал	8,185,100.00	10,137,900.00
210105	Гэрээт ажлын хөлс	10,461,977.00	-
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	12,995,800.00	15,950,800.00
210201	Тэтгэврийн даатгал	8,695,600.00	11,006,700.00
210202	Тэтгэмжийн даатгал	1,075,000.00	1,235,700.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	860,100.00	988,900.00
210204	Ажилгүйдлийн даатгал	214,900.00	247,200.00
210205	Эрүүл мэндийн даатгал	2,150,200.00	2,472,300.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	10,726,410.00	13,237,969.00
210301	Гэрэл, цахилгаан	3,370,647.00	3,221,969.00
210302	Түлш, халаалт	7,355,763.00	9,116,000.00
210303	Цэвэр, бохир ус	-	900,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	5,029,960.00	2,360,740.00
210401	Бичиг хэрэг	999,260.00	778,660.00
210402	Тээвэр, шатахуун	1,600,000.00	113,280.00
210403	Шүүдэн, холбоо, интернэтийн төлбөр	445,500.00	494,200.00
210404	Ном, хэвлэл	235,200.00	100,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,750,000.00	874,600.00
2105	Нормативт зардал	27,437,489.00	27,822,253.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	100,000.00	150,000.00
210502	Хоол, хүнс	27,337,489.00	27,672,253.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	-	4,848,000.00
210604	Урсгал засвар	-	4,848,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	180,000.00	380,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	200,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	180,000.00	180,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,450,000.00	2,207,100.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,450,000.00	2,207,100.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	4,278,841.00	15,638.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	4,267,200.00	-
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	4,267,200.00	-
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	11,641.00	1,607.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	11,641.00	1,607.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	-	14,031.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	14,031.00
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	-
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		



4.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2016 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	623,778,413.00	58,381,953.72	(206,486,933.50)	-	475,673,433.22
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-	-
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	623,778,413.00	58,381,953.72	(206,486,933.50)	-	475,673,433.22
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-	-	-	-	-
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	-	-	-	-	-
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-	-
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	-	-	-
C08	2016 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	623,778,413.00	58,381,953.72	(206,486,933.50)	-	475,673,433.22
D01	2017 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	623,778,413.00	58,381,953.72	(206,486,933.50)	-	475,673,433.22
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-	-
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	623,778,413.00	58,381,953.72	(206,486,933.50)	-	475,673,433.22
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-	-	-	-
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	-	-	-	-	-
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-	-
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-	-	-	-
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	(4,814,625.28)	-	(4,814,625.28)
D09	2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	623,778,413.00	58,381,953.72	(211,301,558.78)	-	470,858,807.94

4.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	187,129,000.00	187,113,362.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	187,129,000.00	187,113,362.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	187,129,000.00	187,113,362.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	121,806,500.00	121,806,500.00
210101	Үндсэн цалин	105,275,900.00	105,275,900.00
210102	Нэмэгдэл	6,392,700.00	6,392,700.00
210104	Урамшуулал	10,137,900.00	10,137,900.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	15,950,800.00	15,950,800.00
210201	Тэтгэврийн даатгал	11,006,700.00	11,006,700.00
210202	Тэтгэмжийн даатгал	1,235,700.00	1,235,700.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	988,900.00	988,900.00
210204	Ажилгүйдлийн даатгал	247,200.00	247,200.00
210205	Эрүүл мэндийн даатгал	2,472,300.00	2,472,300.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	13,252,000.00	13,237,969.00
210301	Гэрэл, цахилгаан	3,236,000.00	3,221,969.00
210302	Түлш, халаалт	9,116,000.00	9,116,000.00
210303	Цэвэр, бохир ус	900,000.00	900,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	2,362,300.00	2,360,740.00
210401	Бичиг хэрэг	778,700.00	778,660.00
210402	Тээвэр, шатахуун	114,000.00	113,280.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	495,000.00	494,200.00
210404	Ном, хэвлэл	100,000.00	100,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	874,600.00	874,600.00
2105	Нормативт зардал	27,822,300.00	27,822,253.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	150,000.00	150,000.00
210502	Хоол, хүнс	27,672,300.00	27,672,253.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4,848,000.00	4,848,000.00
210604	Урсгал засвар	4,848,000.00	4,848,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	380,000.00	380,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	200,000.00	200,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	180,000.00	180,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	707,100.00	707,100.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	707,100.00	707,100.00